

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлагнал /маягт 2/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа	2022 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2022 оны 6-р сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК УБ-ийн дугаар 9007001006 ҮЦ-ны код CUMN Утас 976-7733-0101
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Хүнсний дэлгүүр, хүнсний үйлдвэрлэл, худалдааны зуучлал, франчайзын гэрээний үндсэн дээр бизнесийн үйл ажиллагаа явуулах, гадаад худалдаа, менежментийн зөвлөх үйлчилгээ
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	817,768,643 ширхэг энгийн хувьцаа
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: С.Дашдорж, Санхүүгийн газрын захирал Хянасан: Г.Чинзориг, Гүйцэтгэх захирал
1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Нийт хөрөнгө: 150,843,266 мянган төгрөг Нийт өр төлбөр: 102,372,629 мянган төгрөг Эздийн өмч: 48,470,636 мянган төгрөг
Орлогын тайлан	Борлуулалтын орлого: 111,166,351 мянган төгрөг Нийт ашиг: 563,606 мянган төгрөг Татварын дараах цэвэр алдагдал: - 7,094,252 мянган төгрөг
Өмчийн өөрчлөлтийн тайлан	Хувьцаат капитал (+НТК): 95,597,367 мянган төгрөг Хуримтлагдсан ашиг: - 58,685,324 мянган төгрөг
Мөнгөн гүйлгээний тайлан	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал: 5,873,879 мянган төгрөг Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн урсгал: 307,852 мянган төгрөг Санхүүжилтийн цэвэр мөнгөн урсгал: -6,263,215 мянган төгрөг
2.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт
	Энэ маягтад хавсаргав.

3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Бэлэн мөнгөний цикл 2022 оны 1-р хагас жилд (23) хоног байсан. Бараа материалын дундаж наслалт 41 хоног болж, өглөгийн дундаж наслалт 65 хоног байжээ. Олон улсад үүсээд байгаа ачаа тээвэр, логистикийн хүндрэлтэй холбоотойгоор 2022 оны 1-р хагас жилд бараа материалын дундаж наслалт өссөн байна.
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Компанийн эргэлтийн харьцаа 0.8 байгаа нь дансны өглөг өссөнтэй холбоотой байна. Компанийн борлуулалт, худалдан дүн өссөн нь дансны өглөгийг нэмэгдүүлжээ. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 1-р улиралд 0.3 байгаа нь бараа материалын нөөцийг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Өрийн харьцаа 2021 оны 4-р улиралтай харьцуулахад 0.7 болж нэмэгдсэн нь дэлгүүрийн тоо нэмэгдэж, санхүүгийн өр төлбөр нэмэгдсэнтэй холбоотой. Хүү тооцогддог зээлийг нийт оруулсан хөрөнгөд харьцуулвал (Debt to capital ratio) зээл нь нийт оруулсан хөрөнгийн 26% байна.
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	2022 оны 1-р хагасд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь 63 шинээр салбар дэлгүүр нээж нийт 228 салбартай болоод байна. Компанийн зүгээс 2022 онд 285 салбартай болох зорилтдоо хүрэхээр ажиллаж байна.
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	Байхгүй
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 06-р сарын 13-ны өдрийн тогтоолоор Компанийн Хоол үйлдвэрлэлийн төвийн хөлдөөх болон хүйтэн агуулахын өргөтгөлийн барилгын ажлыг гүйцэтгэх ерөнхий гүйцэтгэгчээр Компанийн нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд болох Премиум Прожектс ХХК-ийг сонгох тухай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхээр шийдвэрлэсэн.	
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	

Компани нь олон нийтээс 28.7 тэрбум төгрөг татан төвлөрүүлснээс 0.1 тэрбум төгрөг МХБ, СЗХ, ҮЦТХТ-ны шимтгэл, төлбөрүүдэд зарцуулагдаж цэвэр дүнгээр 28.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Хөрөнгө оруулалтын зориулалт	Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан төлөвлөгөө /2021.07 сар/	Шинэчилсэн төлөвлөгөө /2021.11 сар/
Нэмэлт дэлгүүрийн хөрөнгө оруулалт ба МТ	19.0	22.6
Түгээлтийн төвийн хөрөнгө оруулалт	3.0	3.0
Хоол үйлдвэрлэлийн төвийн хөрөнгө оруулалт	3.0	3.0
Нийт	25.0	28.5

Хөрөнгө оруулалтын зориулалт	Шинэчилсэн төлөвлөгөө	Зарцуулалт	Биелэлт
Нэмэлт дэлгүүрийн хөрөнгө оруулалт ба МТ	22.6	24.5	108 %
Түгээлтийн төвийн хөрөнгө оруулалт	3.0	0.9	30 %
Хоол үйлдвэрлэлийн төвийн хөрөнгө оруулалт	3.0	1.6	54 %
Нийт	28.5	27.0	95 %

2022 оны 2-р улирлын байдлаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөс:

- **24.5 тэрбум** төгрөгийг дэлгүүрийн хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалттай холбогдох урьдчилсан татан авалтад,
- **0.9 тэрбум** төгрөгийг түгээлтийн төвийн нэмэлт тоног төхөөрөмжийн худалдан авалт, суурилуулалтад,
- **1.6 тэрбум** төгрөгийг хоол үйлдвэрлэлийн төвийн нэмэлт тоног төхөөрөмж, суурилуулалтад тус тус зарцуулсан.

Үлдэгдэл 1.6 тэрбум төгрөгийн санхүүжилт нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө дансанд бүртгэлтэй байна. Уг дүн дээр компанийн дотоод нөөцөөрх мөнгөн санхүүжилт нэмэгдэж түгээлтийн төв болон хоол үйлдвэрлэлийн төв дээр голчлон зарцуулагдахаар төлөвлөж байна.

6. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

2021 оны жилийн үйл ажиллагааны тайланд тайлагнасанаас хойш дараах өөрчлөлтүүд орсон болно. Үүнд:

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") нь 2022 оны 06-р сарын 10-ны өдөр хуралдаж Ванчиг овогтой Ганзоригийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр томилохоор, 2022 оны 06-р сарын 13-ны өдөр хуралдан ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо болон Цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүнийг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан шинэчилсэн "Компанийн засаглалын кодекс"-ийн 2.3 болон 2.4 дэх заалтуудын дагуу өөрчилөхөөр тус тус шийдвэрлэсэн. Ийнхүү өөрчлөлт орсны дараах байдлаар ТУЗ-ийн дарга А.Ганхуяг, ТУЗ-ийн ердийн гишүүд болох А.Ганболд, Г.Бат-Эрдэнэ, О.Батмөнх, Г.Чинзориг, Б.Бат-Эрдэнэ болон ТУЗ-ийн хараат бус гишүүд болох Н.Энхболд, В.Ганзориг, Гари Биондо (Gary Biondo) нар Компанийн ТУЗ-ийг бүрдүүлж байгаа бөгөөд эдгээр нь дор дурдсан хороодын дарга, гишүүдээр томилогдсон. Үүнд:

- **Аудитын хороо:** ТУЗ-ийн хараат бус гишүүн В.Ганзориг (дарга), ТУЗ-ийн хараат бус гишүүн Гари Биондо, ТУЗ-ийн ердийн гишүүн Г.Бат-Эрдэнэ.
- **Нэр дэвшүүлэх хороо:** ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Энхболд (дарга), ТУЗ-ийн хараат бус гишүүн В.Ганзориг, ТУЗ-ийн дарга А.Ганхуяг.
- **Цалин урамшууллын хороо:** ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Энхболд (дарга), ТУЗ-ийн хараат бус гишүүн Гари Биондо, ТУЗ-ийн ердийн гишүүн А.Ганболд.
- **Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо:** ТУЗ-ийн хараат бус гишүүн Гари Биондо (дарга), ТУЗ-ийн ердийн гишүүн О.Батмөнх, ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Бат-Эрдэнэ.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: П.Чинзориг

Албан тушаал: "Сэнтрал Экспресс Си Ви Эс" ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/гэмдэл)



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: С.Дашдорж

Албан тушаал: "Сэнтрал Экспресс Си Ви Эс" ХК-ийн Санхүүгийн газрын захирал

Гарын үсэг:



CENTRAL
express



Санхүү, үйл ажиллагааны гүйцэтгэлийн ТОВЧ танилцуулга – 2022 оны 2-р улирал

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК
MSE: CUMN

2022 оны 7-р сарын 25

Агуулга



1. Стратегийн зорилго
2. Орлого, үр дүнгийн гол үзүүлэлт
3. Үйл ажиллагаа, цар хүрээ
4. Санхүүгийн байдлын тайлангийн гол үзүүлэлт
5. Мөнгөн гүйлгээний тайлангийн гол үзүүлэлт
6. Харьцуулагдах дэлгүүрийн үйл ажиллагаа
7. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан

Стратегийн зорилго



	2019	2020	2021	2022	2023
Дэлгүүрийн тоо	56	103	165	285	360
Цэвэр орлого, төгрөг	37 тб	45 тб	94.2 тб	230.5 тэрбум	390.1 тэрбум
Цэвэр алдагдал	(11.3 тб)	(15.7 тб)	(18.1 тб)	(11.5) тб	7.7 тб
Боломжит татварын хөнгөлөлт	<u>+0.0</u>	<u>+1.14</u>	<u>+1.24</u>		

	Стратеги	
1	Зах зээлд манлайлах	360 дэлгүүрийг шилдэг байршилд нээх
2	Дэд бүтэц	Түгээлтийн төв, хоол үйлдвэрлэлийн төв, мэдээллийн технологийн дэд бүтцийн хүчин чадал, үр ашгийг нэмэгдүүлэх
3	Бүтээгдэхүүн, үйлчилгээний ялгарал	Трэнди бүтээгдэхүүн, үйлчилгээгээр зах зээлээ тэргүүлэх
4	Үнэнч хэрэглэгчдийг нэмэгдүүлэх	Чанар, үйлчилгээний стандартыг өндөрт барьж үнэнч хэрэглэгчдийг урамшуулах
5	Технологийн дэвшлийг нэвтрүүлэх	CU app, Финтек болон дижитал шийдлүүдээр дамжуулж шинэ үнэ цэнийг бүтээх

2022 оны 2-р улирлын онцлох зүйлс



- Цэвэр орлого **69.6 тэрбум ₮**
 - Төлөвлөгөөг **+26.7%** давуулсан
- Цэвэр ашиг(алдагдал): **(1.3) тэрбум ₮**
 - Төлөвлөгөөнөөс **1.8 тэрбум ₮ –р бага**
- Харьцуулагдах дэлгүүрийн борлуулалт өмнөх оны мөн үетэй харьцуулахад: **+125% өссөн**
 - Үйлчлүүлэгчдийн тоо **+116%**, дундаж сагсны үнэ **+4%** өссөн
- Шинээр **+31 дэлгүүр** нээсэн

Орлого, үр дүнгийн гол үзүүлэлт



Тэрбум төгрөг.

	22Q1		22Q2		22H1		
		YoY		YoY		YoY	vs. Plan
Системийн борлуулалт (НӨАТ-тэй)	47.3	+253%	78.5	+244%	125.8	+248%	+19%
Цэвэр орлого	41.6	+247%	69.6	+240%	111.2	+242%	+19%
Нийт ашиг (алдагдал)	-1	+47%	1.6	+184%	0.6	+116%	+140%
Нийт алдагдлын хувь	-2.40%	+13.4%	2.30%	+11.6%	0.54%	+12.2%	+2%
Цэвэр алдагдал	-5.8	-41%	-1.3	+70%	-7.1	+15%	+21%

Үйл ажиллагаа, цар хүрээ



	2022H1	YoY%	2022Q1	FY2021	2021H1
Салбар дэлгүүрийн тоо	228	+80%	197	165	127
Үйлчлүүлэгчдийн тоо	12.9 сая+	+187%	5.6 сая+	13.4 сая+	4.5 сая+
Ажилтны тоо	2,800+	+133%	2,400+	1,600+	1,200+
Вендорын тоо	520+	+30%	410+	400+	400+
Хувьцаа эзэмшигчдийн тоо	9,638	-	9,479	9,546	2

Санхүүгийн байдлын тайлангийн гол үзүүлэлт




Тэрбум төгрөг.

Хөрөнгө (гол үзүүлэлтүүд)	2021Q4	2022H1	Өөрчлө лт₮
Эргэлтийн хөрөнгө	40.8	38.4	-2.4
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	4.1	3.9	-0.2
Борлуулах зорилгоор эзэмшиж буй үнэт цаас ба зээл	16.8	0.1	-16.7
Бараа материал	14.0	23.4	+9.4
Эргэлтийн бус хөрөнгө	87.1	112.5	+25.4
Нийт хөрөнгө	127.8	150.8	+23.0

Өр төлбөр, эздийн өмч (гол үзүүлэлтүүд)	2021Q4	2022H1	Өөрчл өлт₮
Нийт өр төлбөр	71.5	102.4	+30.9
Эргэлтийн өр төлбөр	30.0	46.9	+16.9
Худалдааны болон бусад өглөг	22.7	39.2	+16.5
Богино хугацаат зээл	2.0	2.0	-
Эргэлтийн бус өр төлбөр	41.4	55.5	+14.1
Урт хугацаат зээл	14.4	14.4	-
Урт хугацаат түрээсийн өглөг	27.0	41.0	+14.0
Нийт эздийн өмч	56.4	48.5	-7.9
Нийт өр ба эздийн өмч	127.8	150.8	+23.0


Мөнгөн гүйлгээний тайлангийн гол үзүүлэлтүүд (тохируулсан)



	2021H1	2022H1	YoY%
Үйл ажиллагааны МГ	(6.5)	5.9	+12.4
Хөрөнгө оруулалтын МГ*	2.6	(14.2)	-16.8
Чөлөөт мөнгөн урсгал	(3.9)	(8.3)	-4.4
Санхүүгийн МГ	1.7	(6.3)	-8.0
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4.0	3.8	-0.2

*2022 оны 2-р улиралд Борлуулах зорилгоор богино хугацаат үнэт цаас худалдаж авахад төлсөн 2.6 тэрбум төгрөг, үнэт цаас борлуулсан 17 тэрбум төгрөгийн орох мөнгөн урсгалыг тусгаагүй буюу үндсэн хөрөнгөтэй холбогдох хөрөнгө оруулалтыг л авч үзэх байдлаар тохируулсан.


Харьцуулагдах дэлгүүрийн гүйцэтгэл (ҮоҮ%)



Харьцуулагдах дэлгүүрийн гүйцэтгэл – Борлуулалт



Өдрийн дундаж борлуулалт Үйлчлүүлэгчийн тоо Сагсны үнэ




Татан төвлөрүүлсэн санхүүжилтийн зарцуулалт ба үлдэгдэл



Хөрөнгө оруулалтын зориулалт (2022.06.30)	Төлөвлөгөө	Явц	Явцын хувь
Нэмэлт дэлгүүрийн хөрөнгө оруулалт ба МТ	22.6	24.5	108 %
Түгээлтийн төвийн нэмэлт тоног төхөөрөмжийн худалдан авалт, суурилуулалт	3.0	0.9	30 %
Хоол үйлдвэрлэлийн төвийн нэмэлт тоног төхөөрөмжийн худалдан авалт, суурилуулалт	3.0	1.6	54 %
Холбогдох зардлын дараах татан төвлөрүүлсэн хөрөнгө	28.5	27.0	95 %

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2022 оны 5-р сарын 24-ний 281 дугаар тушаалын дагуу Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-д хяналт, шалгалт хийгдсэн бөгөөд уг хяналт шалгалтын үр дүнд татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт зөрчилгүй, хуваарийн дагуу хийгдэж байна гэсэн дүгнэлт гарсан.

Хувьцааны үнийн хөдөлгөөн



Үнэт цаасны бүртгэлийн ангилал



МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

"СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛИЙН АНГИЛАЛ АХИУЛЛАА

2022-05-05 16:14:43

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 20 дугаар зүйлийн 20.2, 20.3 дахь заалтууд болон "Сэнтрал Экспресс Си Ви Эс" ХК-ийн 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 151242-16/22-304 тоот албан бичгээр ирүүлсэн ангилал ахиулах тухай хүсэлт зэргийг тус тус үндэслэн "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн А/42 тоот тушаалаар "Сэнтрал Экспресс Си Ви Эс" ХК-ийн үнэт цаасыг "III" ангиллаас ахиулан "II" ангилалд бүртгэлээ.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК

- 10.0 тэрбум төгрөг, Хөрөнгө оруулалтын зээл
- 3.0 тэрбум төгрөг, Зээлийн шугам
- 2.0 тэрбум төгрөг, Баталгааны шугам

Сэнтрал Фүүдс ХХК

- 3.0 тэрбум төгрөгийн зээлийн дахин санхүүжилт
- 6.1 тэрбум төгрөгийн зээлийн хуваарийн өөрчлөлт

Орлогын төлөвлөгөө (IPO / 2021.07)



Орлогын тайлан (тэрбум ₮)	2022T	2023T	2024T	2025T	2026T	2027T	2028T	2029T	2030T
Дэлгүүрийн тоо (IPO)	285	360	360	360	360	360	360	360	360
Орлого	237.9	390.1	475.4	518.0	561.4	595.1	630.8	668.7	708.8
Борлуулалтын өртөг	(229.8)	(356.9)	(424.1)	(449.6)	(475.7)	(502.8)	(531.1)	(559.6)	(590.8)
Нийт ашиг	8.0	33.2	51.3	68.3	85.7	92.3	99.8	109.0	118.0
Ерөнхий ба удирдлагын зардал	(9.8)	(11.0)	(11.4)	(11.8)	(12.2)	(12.5)	(13.0)	(13.5)	(14.1)
Үйл ажиллагааны ашиг, алдагдал	(1.7)	22.2	39.9	56.5	73.5	79.8	86.8	95.5	103.9
Цэвэр санхүүгийн зардал	(1.7)	(2.3)	(1.9)	(1.5)	(1.1)	(0.6)	(0.1)	-	-
Санхүүгийн түрээсийн зардал	(8.7)	(11.6)	(13.6)	(12.6)	(11.5)	(11.7)	(10.1)	(8.2)	(7.7)
Татварын өмнөх ашиг	(12.0)	9.5	25.6	43.6	61.8	68.0	76.7	87.3	96.2
Татварын зардал	-	(0.7)	(2.5)	(7.3)	(14.0)	(15.5)	(17.2)	(19.1)	(20.7)
Цэвэр ашиг, алдагдал	(12.1)	7.7	22.0	35.2	47.0	52.1	59.4	68.2	75.6

***Үнэт цаасны танилцуулгад тусгасан тоо нь тухайн үеийн тооцсон дэд бүтцийн хүчин чадлаар хязгаарлаж тооцсон болно. Удирдлагын зүгээс ирээдүйд 360-с олон тооны дэлгүүртэй байна гэж үзэж байгаа болно.**

Анхаарал хандуулсанд баярлалаа

